



ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор
Л.Жаргалсайхан Утас: 70272582
[И-мэйл Jargalsaikhan_tuv@yahoo.com](mailto:I-jargalsaikhan_tuv@yahoo.com)
Аудитын менежер
Т.Майцэцэг
Аудитор
Ц.Саранчимэг
Утас: 70273204
[И-мэйлTsaranchimeg@yahoo.com](mailto:I-maylTsaranchimeg@yahoo.com)

• Танилцуулга	3
• Санхүүгийн дотоод хяналт	3
• Гол шийдлүүд	4
• Залруулаагүй алдаа	4
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	4
• Аудитын санал дүгнэлт	4

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг
Төрийн байгууллагуудын ордон

Прокурорын газар 2013 оны Санхүүгийн Тайланд

ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

1. Прокурорын газрын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Прокурорын газрын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаар бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд аймгийн Прокурорын газрын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

1. Нэмэлт санхүүжилт орон нутгаас өгсөн байна.
2. Өмнөх жилээс бараа үйлчилгээний бусад зардал 60 хувиар өссөн ба бараа материалын үлдэгдэл 2 дахин өссөн байна.
3. Санхүүгийн программын ашиглалт хангалтгүй байна. Үүнд эд хариуцагчийн программ шинээр авч ашиглаагүй, мөн цалингийн программ ашиглахгүй байна.
4. Албан хаагчдын цалин бодож олгохдоо ажилтнуудад 1481.4 мянган төгрөгийн цалин илүү олгож төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан байна.
5. Техникийн комиссын актгүй 2533.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл автомашинд авсан байна.
6. Хэвлэл захиалгын үнэ 158.6 мянган төгрөгийн зардал гаргаж нам, олон нийтийн байгууллагын сонин хэвлэлийг захиалж төсвийг үргүй зарцуулсан байна.
7. Прокурорын нэмэгдэл урамшуулал 1385.0 мянган төгрөгөөс 138.5 мянган төгрөгийн татварыг аваагүй байна.
8. Үндсэн хөрөнгийн элэгдэлийг зөрүүтэй тооцсон байна.
9. Тооцоо нийлсэн актыг үйлдэхдээ зөвхөн тооцооны үлдэгдлийн баталгааг бичиж тооцооны баримтын жагсаалтыг бүрэн хөтлөхгүй байна.

10.Дотоод хяналтын баг ажилладаггүй,
удирдлагын зөвлөл ажилладаг.

ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ
тайлбар мэдүүлэг хүлээж байгаа

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан
талаар тайлбар ирүүлнэ үү

Аудитыг дуусгаж аудитын явцад олж
авсан ажлын баримтанд үндэслэн акт,
албан шаардлага өгсөн тул зөрчилгүй
дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт
санал оруулсан байгаа

Ерөнхий Аудитор 2014.02.14-ны өдөр
санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан
бодогч З.Батцэнгэл болон бусад
бидэнтэй хамтран ажилласан
ажилчдын байнгын дэмжлэг туслалцаа
бидний ажилд дэмжлэг болж байсанд
гүнээ талархаж байна.

Төв аймгийн Аудитын Газар

2014.02.14

Танилцуулга

1. Бид аймгийн Прокурорын газрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Прокурорын газрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Прокурорын газрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3.ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Прокурорын газрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Прокурорын газрын даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Прокурорын газрын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1. Орлого, санхүүжилтийн талаар

1. Төсвийн сар, улирлын хуваарийг үзэж, хуваарийн дагуу санхүүжилтээ авсан эсэхийг Аймгийн Прокурорын газрын баримтанд шалгахад санхүүжилт нь сар бүрийн хуваарийн дагуу хийгдсэн байна.
2. 2013 оны батлагдсан төсөв 425053.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 443466.1 төгрөгийн санхүүжилт авч 18412.6 мянган төгрөгийн санхүүжилт илүү авсан мөн аймгийн орон нутгийн төсвөөс 18388.6 мянган төгрөгийн төсөв нэмж нийт 36801.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.
3. 2013 онд 268.5 мянган төгрөгийн лист, 3781.6 мянган төгрөгийн татварын хөнгөлөлт, 250.0 мянган төгрөгийн андуурсан гүйлгээний нийт 4301.1 мянган төгрөг харилцах дансанд орсныг ЗГазрын 2012.12.22-ны өдрийн 205 тоот тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.11.3-7.11.4-ийн дагуу орлого бууруулах гүйлгээ хийсэн байна.
4. Санхүүгийн тайлан тэнцэлд санхүүжилтийн орлого улсын төсвөөс 443466.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 18388.6 мянган төгрөг нийт 461855.4 мянган төгрөгийн санхүүжилт авсныг бүрэн тусгасан байна.
5. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдөр 205 тоот тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам 7.11.2-т төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлсэн тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө гэж заасан бөгөөд тайлагнахдаа санхүүжилтээ бууруулалгүйгээр тайлагнасан байна.

2.Бараа үйлчилгээний урсгал зардал

1. Бараа үйлчилгээний урсгал зардлын нийт 158827.0 мянган төгрөгөөс төсөвт төвлөрүүлсэн 60000.0 мянган төгрөгийг хасч тооцвол 98827.0 мянган төгрөгийн зардалд тогтмол зардал 22.8% буюу 22507.5 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардал 77.2% буюу 76319.5 мянган төгрөгийн эзэлж байна. Тогтмол зардал нь өмнөх жилийнхээс 8595.6 мянган төгрөгөөр буурсан бол бусад зардал нь 46549.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь аймгаас нэмж өгсөн засварын зардалаас гадна улсын төсвийн санхүүжилтээс шуудан холбоо интернит сүлжээ сувгийн зардал, эд хогшил худалдан авах зардал өссөнтэй холбоотой байна.
2. Мөн үүнээс гадна өмнөх оноос бичгийн хэргийн зардал нилээд өссөн байна. Үүнд 2012 онд жилийн турш принтерийн хор 5 ширхэг 296.0 мянган төгрөг, бичгийн цаас 62 боодол 403.0 мянган төгрөгийн зардал гарч байсан бол 2013 онд принтерийн хор 7 ширхэг 596.0 мянган төгрөг, бичгийн цаас 109 боодол 717.5 мянган төгрөгийн зардал гаргаж өмнөх оноос 2 дахин өссөнөөс гадна 2013 оны жилийн эцэст 2-3 жилийн хэрэгцээний бичиг хэргийн зардал болох притерийн хор 15 ширхэг 975.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
3. Хэвлэл захиалгын үнэ 158.6 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төрийн алба болон гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй холбогдолгүй /нам, олон нийтийн байгууллагын/ сонин хэвлэлийг олноор захиалж төсвийг үргүй зарцуулсан байна.
4. Түлш халаалтын зардлаас 3020.4 мянган төгрөг хэмнэснийг Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалын дагуу Төрийн санд хэмнэсэн зардлыг зарцуулах хүсэлтийг гаргаж нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардалд 740.0 мянган төгрөг, төлбөр хураамж бусад зардалд 2280.5 мянган төгрөг шилжүүлэн зарцуулсан байна.

3.Цалин

1. Цалингийн тооцооны хүснэгтийг бүрэн хийгээгүй ажиллагсад цалин олгох хүснэгтэнд гарын үсэг зуруулсан байна. Нийт ажиллагсадаас хэдэн хүн ямар нэмэгдэл авч байгааг сар бүрийн цалингийн тооцооны хүснэгтээс харах боломжгүйгээр хийсэн нь санхүүгийн программыг бүрэн ашиглаагүйтэй холбоотой байна.
2. Цалингийн тооцооллыг санхүүгийн программаас эхсэл файлд хөрвүүлэн шалгах байсан ч нягтлан бодогч нь цалингийн программ ашиглаагүйгээс шууд эхсэл программ дээрх мэдээлэлээс шалгахад цалингийн нэмэгдэлийг хийгээгүйгээс ашиглахад төвөгтэй байсан. Цалингийн зардал мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайланд 271958.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна.
3. Ажилчин албан хаагчдын цалинг ХААН банкны нэрийн картаар олгосон ба цалин олгох хүснэгтэнд ажиллагсдаар гарын үсгийг бүрэн зуруулсан байна. 2013 онд нийт 29 орон тоо 327315.2 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдаж гүйцэтгэлээр 25 орон тоогоор 271958.5 мянган төгрөг зарцуулж, цалингийн зардал 4 орон тоо 55356.7 мянган төгрөгөөр батлагдсан зардал хэмнэгдсэн байна.
4. Цалингийн баримтанд ур чадварын нэмэгдэлийг улирал бүр тушаал гарган 20-25 хувиар нэмэгдлийн дээд хэмжээгээр үйлчилгээний ажилтнуудад тогтмол олгосон нь Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 7-д заасан заалт зөрчигдөж хавтгайруулан олгосон байна. Цалингийн урьдчилгаа 4400.0 мянган төгрөг олгож цалингийн урьдчилгааг бүрэн суутгасан байна.
5. Албан хаагчдын цалин бодож олгохдоо ажилтнуудад илүү бодож олгон 1481.4 мянган төгрөгийн цалин илүү олгож төсвийг аривлан хэмнэлтгүй зарцуулсан байна.
6. УЕП-ын 2012 оны А/17 тоот тушаалаар батласан журмын дагуу олгож буй шүүх эмнэлгийн задлан шинжилгээнд оролцсон прокурорын нэмэгдэл урамшуулал 1385.0 мянган төгрөгөөс 138.5 мянган төгрөгийн татварыг аваагүй байна.

4.Бараа материал

1. Бараа материал 2013 оны эхэнд 3195.8 мянган төгрөг, 12305.3 мянган төгрөгийн материал нэмэгдэж , 7015.4 мянган төгрөгийн материал зарцуулж , эцсийн үлдэгдэл 8485.6 мянган төгрөг байна. Тайлант онд бичиг хэргийн материал 7747.3 мянган төгрөг, аж ахуйн материал 1951.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2607.0 мянган

төгрөгийн материал орлого авч, бичиг хэргийн материал 6808.2 мянган төгрөг, аж ахуйн материал 207.2 мянган төгрөгийн материал зарцуулсан байна. Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2 дахин өссөн байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.3-д Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна гэснийг зөрчин дараа оны материал нөөцөлж байгаа нь төсвийн хэмнэлтийг өөр зардалд гүйлгэн зарцуулах эх үүсвэр болж байна.

2. Бараа материалын тайлан гаргалтыг шалгахад шатахууны тайланг гаргаагүй шууд зардалд 10071.1 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын тайлангаар дамжуулалгүй хаасан байна. Мөн бараа материалын тайлан гаргахдаа бичиг хэргийн зардалд сэлбэг хэрэгслийг оруулан тайлагнасан байна. Энэ нь Прокурорын байгууллагын санхүүд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт бараа материал худалдан авах үед ДТ-хангамжийн материал холбогдох дэд данс КТ- дансны өглөг , бараа материал тавьж олгохдоо ДТ-Зардлын зүйлээр КТ-Хангамжийн материал холбогдох дэд данс гэснийг мөн бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө гэж заасан нь хэрэгжээгүй байна.
3. Тооллогын бүртгэлээр бичиг хэргийн материал 1256.0 мянган төгрөг, аж ахуйн материал 4622.7 мянган төгрөг, бусад хангамжийн материал 2607.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгааг тооллогын комисс баталгаажуулсан байна.
4. Бараа материалыг зохих журмын дагуу орлого авч, зарлагдсан боловч шатахууны тайланг эд хариуцагч хийгээгүй, санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга тайланд орлого зарлагыг тайлагнаагүй байна.
5. Шатахууны тооцоо бодолтыг шалгахад ШШАлба, Цагдаагийн газраас болон бусад газраас шатахуун хийж хамтарч томилолтоор явахдаа шатахууны орлогыг ямар байгууллагаас хэдийг авч хийсэн нь тодорхойгүй их хэмжээний шатахуун хэмнэсэн тооцоо харагдаж шатахууны тооцоог үндэслэлгүй болгосон байна.

5.Үндсэн хөрөнгө

1. Төв аймгийн Прокурорын А/38 тоот тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах тооллогын комисс томилж тооллогыг тогтоосон хугацаанд явуулж тооллогын комисс нь ашиглах боломжгүй болсон хөрөнгийг жагсаалтыг гаргаж Төрийн өмчийн хороонд явуулсан байна.
2. Нягтлан бодогч хөрөнгийн тооллогын үлдэгдэлтэй тулган тооцоог бодож хөрөнгийн ямар нэгэн дутагдал зөрчил гаргаагүй байна.
3. Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 434850.9 мянган төгрөг, тайлант онд 22532.0 төгрөгийн хөрөнгө орлогоор бүртгэж оны эцэст 457382.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.
4. 2013 онд төсвийн хөрөнгөөр 13000.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл , 220.0 мянган төгрөгийн программ хангамж , УЕПГазраас 4592.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4720.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл ирснийг орлого авч дансанд бүртгэсэн байна.
5. Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журмын дагуу элэгдлийг тооцохдоо 2013 онд авсан тавилга хэрэгсэлийн элэгдлийг 350.5 мянган төгрөгөөр дутуу, 2009 онд авсан компьютер, скайнерын элэгдлийг 406.1 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.

6.Мөнгөн хөрөнгө

1. Санхүүгийн программ ашиглалт хангалтгүй байна. Эд хариуцагчийн программ авсан ч ашиглаагүй байгаа нь материалын тайлангийн орлого, зарлагын падан хэвлэгдэж гараагүйгээс программаар гаргасан материалын тайлан байхгүй байна. Мөн цалингийн программ ашиглаагүй байна.
2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлийг төрийн сангийн хуулгатай тохируулан шалгахад зөрүүгүй байна.
3. Техникийн комиссын актгүй 2533.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл автомашинд авсан байна. Их гэрэл дахин авч байгаа нь хэний буруугаас шалтгаалсныг тодруулж хариуцлага тооцолгүй , техникийн комиссын актын дүгнэлтгүйгээр хэн нэгэн буруутай

этгээдийг тодорхойлолгүйгээр автомашины их гэрэлийг 959.2 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг үргүй зарцуулсан байна.

7. Авлага ,өглөгийн талаар

1. Аймгийн Холбооны газар, Зуунмод ХҮТөв, ТЕГазрын төв аймаг дахь хэлтэс , Төв Чандмань ДЭХГ, Цогт-Өлзийт ХХК, Петровис ШТС, ШҮГазар, Мандухай цэцэн ХХКомпаниудтай тооцоо нийлсэн боловч зарим газруудтай тооцооны баримтын жагсаалтыг хөтлөлгүйгээр тооцоо нийлсэн актыг хөтлөсөн нь өмнөх онд гарч байсан алдаа зөрчил давтагдсаар байна.
2. Татвар, НДаатгалын тайлангаар өр авлагагүй гарсан байна.
3. Өглөгийн тайлангаар Цалин, НДШимтгэл,Татварын өглөг авлагыг зардлын төрлөөр хийсэн ба өглөгийн тайланд бусад зардалд 41306,9 мянган төгрөг, авлагын тайланд бусад зардал 22661.7 мянган төгрөгийг бөөн дүнгээр тайлагнасан байна. Энэ нь нийт дүнгээр 63968,8 мянган төгрөгийн гэрэл цахилгаан, түлш халаалт, шуудан холбоо, тээвэр шатахуун, томилолт, урсгал засварын зардалын өглөгийг санхүүгийн программд зардлын зүйлээ зөв сонгоогүйтэй холбоотой өмнөх жилд гарч байсан алдаа мөн давтагдсан байна.

8. Дотоод хяналтын талаар

1. Төв аймгийн Прокурорын газарт байгууллагын дотоод хяналтын зөвлөл байхгүй. Харин байгууллагын дэргэд удирдах зөвлөл ажилладаг. Удирдах зөвлөлийн тайлан болон хурлын протокол нь нууцын зэрэглэлд хамаарагдах баримт бичиг тул үзэгдээгүй болно.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан 8 хэсгүүдийн дотоод хяналтын ситем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5.Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- 1) Төсвийн тухай хуулийн 6,4,1-ийн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэснийг хэрэгжүүлж ажиллах
- 2) Санхүүгийн тайлангийн тодруулга тайлангуудаас бараа материалын тайлан /шатахуун, сэлбэг хэрэгсэл/ болон өглөг авлагын тайланг /бэлтгэн нийлүүлэгч байгууллага бүрээр тооцоо үүсгэн/ холбогдох дэд дансуудаар НББББичгийг үндэслэн хөтөлж байх
- 3) Нам олон нийтийн байгууллагын сонин хэвлэлийг төсвийн хөрөнгөөр захиалж төсвийг зарцуулж байгааг зогсоох
- 4) Нэмэгдэл урамшуулалаас ХХОАТатварын тухай хуулийн дагуу татварын суутган авч байх
- 5) Автомашины оношлогоо болон техникийн комиссын дүгнэлтгүйгээр сэлбэг хэрэгсэл авахгүй байх
- 6) Албан хаагчдын хөдөлмөрийн хуулиар амралтыг биеэр эдлүүлэн цалин давхардуулан олгож байгааг зогсоох
- 7) Ур чадварын нэмэгдэлийг төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад хавтгайруулан олгохгүй байх

- 8) Төсвийн хуулиар тогтоосон төсвийн нэг жилийн батлагдсан зардлын хүрээнд зардлыг гаргаж бараа материал нөөцлөх болон дараа оны зардлыг урьдчилан төлөхгүй байх

6.Эдгээр асуудлуудыг ААГ болон Прокурорын газрын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Дээр дурьдсан алдаа зөрчлүүд санхүүгийн тайлангийн аудитын явцад залруулагдаагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Менежментийн захидлын хариу 2014.02.17-ны өдрийн № 02/101, 02/102 тоот бичгээр ирснийг нягтлан үзэж хавсаргав.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан талаар 2013.07.04-ний өдрийн 2/254 тоот албан тоотоор удирдлагын захидлын хариуг ирүүлсэн байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.16